

**СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

Төрийн удирдлагын чиглэлээр:

11 сарын 7,8-нд аймгийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.

The unity of Sukhbaatar уриан дор 11 сарын 5,6-нд Төрийн албан хаагчдын 5-н төрөлт спортын наадам зохион байгуулж 150 албан хаагч, 11 сарын 25,26-нд малчдын 6-н төрөлт спортын наадам зохион байгуулж 200 малчид хамрагдлаа.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран “Зөвөөр зөвлөө-Урьдчилан сэргээлээ” аяны хүрээнд аливаа хүчирхийллийг бууруулах, иргэдэд хуулийн мэдлэг олгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой “Дэвжээ” тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 8 байгууллагын 40 хүнийг хамруулсан.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Цагаан зээрийн эргүүл хяналт шалгалтыг 7 удаа зохион байгууллаа. 8 тээврийн хэрэгсэл шалгаснаас 4 зөрчил илрүүлж, зөрчлийн хэргийн материалыг бүрдүүлэн хэрэг үүсгэн шалгагдаж байгаа 3 хэрэг, арга хэмжээ авсан 1

Мөнххаан сумын Нарансарангын ууланд байсан аргаль хонийг Дархан хаан ууланд нутагшуулсан.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

БШУЯ-ны 2022-2023 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын 2,10 дугаар зорилт, Тогтвортой хөгжлийн 4-р зорилтын хүрээнд "ХАРИЛЦАН ТУСАЛЪЯ, ХАМТДАА ХӨГЖЬЕ "ЗОЧИН БАГШ" Үйл ажиллагааг ЕБС, хүүхдийн цэцэрлэг хамтран зохион байгууллаа.

2022 оны 10 сарын 24 өдөр Цэцэрлэгийнхээ нэгдсэн эцэг эхийн хурлыг амжилттай зохион явуулж 2022-2023 оны хичээлийн жилийн "зорилго" "зорилт" хийгдэх ажлын төлөвлөгөө болон сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа, Хүүхэд хамгаалалын талаар сургалтыг явуулж. Мөн сэтгэл ханамжийн судалгаа авч цаашид хамтран ажиллах эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн батлан сонголоо. Байгууллагын эцэг эхийн хуралыг хийж эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгууллаа.

"МОНГОЛ БАХАРХАЛ" сарын аяныг угтан Үндэсний өв соёл ёс уламжлал ардын язгуур урлагийг бяцхан шавь нартаа танин мэдүүлэх бусдад түгээн дэлгэрүүлэх зорилготой "ӨВ ЭРДЭНЭ", "АВЬЯАСЛАГ БАГАЧУУД" 2022 Урлагийн наадам цэцэрлэгийн 6 бүлгийн дунд амжилттай зохион байгууллаа.

Соёл урлагийн чиглэлээр:

Монгол Улсын Соёлын Яамнаас "Зүүн бүсийн Жишиг Соёлын төв"-д 18.000.000 сая төгрөгний техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн **хөрөнгө оруулалт** хийгдлээ. Чанга яригч, чадлын өсгөгч, пульт, зайны микрофон, утастай микрофон, зурвас хувиарлагч, суурин компьютер, 3 үйлдэлт принтер, зургийн аппарат зэрэг 10 нэр төрлийн 18 ширхэг техник хэрэгслийг хүлээж авлаа.

Соёлын аялал жуулчлалын хүрээнд Улсын тэргүүний цэцэрлэгтэй хамтран Үндэсний өв соёл ёс уламжлал ардын язгуур урлагийг хүүхэд багачуудад танин мэдүүлэх бусдад түгээн дэлгэрүүлэх зорилготой "Өв эрдэнэ" **"Авьяаслаг багачууд"** 2022 Урлагийн наадмыг амжилттай зохион байгууллаа. Урлагийн наадамд 6 ангийн 70 хүүхэд хамрагдаж, танхимаар 80 хүнд хүргэлээ.

Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор цахим контент бэлтгэсэн. Контентын анхны дугаарт Сумын Засаг дарга Б.Батхүрэлийг оролцуулсан.

Угийн бичиг хөтлөх хичээл болон мэдээлэлийг цахимаар 12 удаа олон нийтэд хүргэсэн.

"Үлгэрч гэр бүл" цахим уралдаан зарлаж, цувралаар 19 удаа мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулсан.

Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр буюу Монгол бахархалын өдрийг угтан уншигчдадаа зориулан түүхэн номын үзэсгэлэнг гаргасан.

Улсын тэргүүний Номын сангаас санаачилан Монгол бахархалын өдрийг тохиолдуулан **"Монголын нууц товчоонд нэвтрэхүй"** тэмцээнийг ЕБС-ийн номын сан, түүхийн танхимтай хамтран зохион байгууллаа.

МЭДЭЭ ГАРГАСАН :

Хууль, эрх зүйн мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч:

Э.Дэлхийцэцэг

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/